

БНМАУ-ЫН БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ КОЛЛЕГИ, БНМАУ-ЫН
БИЕЙН ТАМИР СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ГИШҮҮД, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙ-
ЦЭТГЭХ, ЗАХИРГААНЫ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН
Т О Г Т О О Л

1984 оны 12 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 47/72/228. Улаанбаатар
хот

"Барилгачин спорт клуб" байгуулах
тухай

Барилгачдын дунд зохиогдох биеийн тамир спорт, соёл хүмүүж-
лийн ажил ялангуяа барилгачин задуучуудын чөлөөт цагийг үр
ашигтай зохион байгуулалттай өнгөрүүлэх явдал онцгой чухал ач
холбогдолтойг тэмдэглэн Барилга, барилгын материалын үйлдвэ -
рийн яамны коллеги, Биеийн тамир спортын улсын хорооны гишүүд,
Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн хурлаас
ТОГТООХ нь:

Нэг. Найрамдлын районы биеийн тамир спортын хороо нь барил-
гачдад зориулагдсан спорт заал, байрыг ашиглаж байгаатай холбог-
дуулан тус районы Биеийн тамир спортын хороог Барилга, барилгын
материалын үйлдвэрийн яамны "Барилгачин спорт клуб"-тэй нэгтгэн
байгуулсугай.

Хоёр. "Найрамдлын районы Биеийн тамир спортын хороо-Барилга-
чин спорт клуб"-ын ажиллах журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг I
дүгээр хавсралтаар, тус хорооны клубын тэргүүлэгчдийг 2 дугаар
хавсралтаар, түүний харьяанд ажиллах биеийн тамир спортын хамт-
лагуудыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Тус тусын районы нутаг дэвсгэрт байгаа барилгын
байгууллагуудыг "Найрамдлын районы биеийн тамир спортын хороо-
Барилгачин спорт клуб"-ын биеийн тамир спортын арга хэмжээнд
оролцуулж байхыг Хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны Хөдөлмөр ний-
гэмлэг /н.Баяраа/, Сүхбаатарын районы Биеийн тамир спортын хороо
/н.Доржжүгдэр/, Октябрийн районы биеийн тамир спортын хороо
/н.Гунгаа/ нарт даалгасугай.

Дөрөв. Барилгачдын бие бялдрыг чийрэгжүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв зохион байгуулахад чиглэгдсэн биеийн тамирын арга хэмжээг "Найрамдлын районы биеийн тамир спортын хороо-Барилгачин спорт клуб"-ын төлөвлөгөө, заавар, графикийн дагуу зохион байгуулж явуулахыг Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамны харьяа байгууллагуудын дарга нарт даалгасугай.

Тав. Биеийн тамираар хөдөлмөрчдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, спорт олон түмний арга хэмжээ зохиоход үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагуудын хүч хөрөнгийг нэгтгэж биеийн тамир спортын материаллаг бааз болон бусад арга хэмжээг санхүүжүүлж байхыг Найрамдлын районы Биеийн тамир спортын хороо-Барилгачин спорт клубын тэргүүлэгчдийн дарга н. Цэрэнбаатарт даалгасугай.

Зургаа. Найрамдлын районы биеийн тамир спортын хороо-Барилгачин спорт клуб /н. Лувсандагва/-д даалгах нь:

а/барилгачдын дунд зохиох биеийн тамир спортын календарчилсан төлөвлөгөөг хорооны жил, улирлын төлөвлөгөөнд байнга тусган хэрэгжүүлэх.

б/биеийн тамир спорт, үйлдвэрлэлийн гимнастикийн арга зүйч зааварлагчдыг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах.

Долоо. Энэ тогтоолын биелэлтэнд байнгын хяналт тавьж, шаардлагатай үед асуудал боловсруулж Барилга, барилгын материалын үйлдвэрийн яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд оруулан шийдвэрлүүлж байхыг Барилга, барилгын материалын үйлдвэрийн яамны боловсон хүчний газар /н.Гүрдорж/, Найрамдлын районы биеийн тамир спортын хороо /н.Лувсандагва/, Хотын биеийн тамир спортын хороо /н.Содномзундуй/-д тус тус даалгасугай.

БНМАУ-ЫН БАРИЛГА, БАРИЛГЫН
МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ-
НЫ САЙД

Л.ЦЭРЭНБААТАР

БНМАУ-ЫН БИЕИЙН
ТАМИР СПОРТЫН
УЛСЫН ХОРООНЫ
ДАРГА

Н.ЦЭРЭНБААТАР

УЛААНБААТАР ХОТЫН
АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ
ДАРГА

С.МОНХУАРГАЛ